



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 5/26

Ховд

Б.Алтангэрэлийг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.10, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01 дүгээр зөвлөмжийн 2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 05/8037 тоот албан бичгээр хянаадаж ирсэн Бямбасүрэнгийн Алтангэрэлийг ковидын нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Боловсролын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Алтангэрэлд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний Т3-10-3 дахь шатлал буюу 981742 төгрөг /есөн зуун наян нэгэн мянга долоон зуун дөчин хоёр/-өөр цалинжуулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 25 хувиар, бусад нэмэгдлүүдийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу тооцож олгохыг нягтлан бодогч /Б.Угантуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Б/20 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

5/26/2021
Zah B/26 Kh